ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 08 өдөр Дугаар А/18 Мөрөн сум

Ажил хүлээлцэх комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, 83.2, 83.3 заалт, Сумын Засан даргын 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/08 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан Д.Эрдэнэцэцэгийн ажлыг уг албан тушаалыг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн Г.Дашмаад хүлээлгэн өгөх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Хишигбаатар	Хууль эрх зүйн мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Болорцэцэг	Хүнс,жижиг дунд үйлдвэрлэл хоршоо хариуцсан мэргэжилтэн
	А.Энхтөр	Аж ахуйн нярав

2.Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга бөгөөд төсвийн ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан Д.Эрдэнэцэцэгийн ажлыг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон Г.Дашмаад хүлээлгэн өгөх ажлыг 2025 оны 05 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн ажлын 5 хоногт багтаан дуусгахыг Комиссын дарга Хишигбаатар үүрэг болгосугай.

3.Д.Эрдэнэцэцэгийн ажлыг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон Г.Дашмаад хүлээлгэн өгөхдөө баримт бичиг, техник хэрэгсэл, эд хогшлыг нэг бүрчлэн акт үйлдэн хүлээлцэхийг комиссын нийт гишүүдэд даалгасугай.

ДАРГА Н.НАМЖИЛНОРОВ

C:\My Documents\ ТУШААЛ .doc